

Санваарын болон Хавсралт Байгууллагуудын Удирдагчдад Зориулсан Сургалтын Хөтөлбөрийн Талаарх Мэдээлэл

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

2005 оноос 2008 оныг дуустал

ОРШИЛ

Энэ баримт бичиг нь (1) гэрт ашиглагдах, (2) Сүмийн нэгжүүдэд ашиглагдах зориулалтаар 2005 оноос 2008 оныг дуустал төлөвлөгдсөн сургалтын хөтөлбөрийн материалуудыг агуулдаг. Үүний нэг хувийг санваарын болон хавсралт байгууллагын удирдагч бүрт өгөх ёстой. Үүнийг хэсгийн зөвлөлийн хурал дээр авч хэлэлцэж байх ёстой.

Сүмийн Сургалтын Хөтөлбөрийн тойм

Есүс Христийн сайн мэдээг мэдэж, үүний дагуу амьдрахад нь гишүүдэд туслахын тулд Сүм сургалтын хөтөлбөрийн материалуудыг гаргадаг. Судрууд болон бошиглогчдын заасан зүйлс нь сургалтын хөтөлбөрийн үндэс суурь юм.

Сүмийн сургалтын хөтөлбөр нь: *сургалтын үндсэн хөтөлбөр* түүнчлэн *сургалтын ерөнхий хөтөлбөр* гэсэн хоёр төрлөөс бүтдэг.

Сургалтын үндсэн хөтөлбөр нь Сүм саяхан зохион байгуулагдсан бүст буюу *сургалтын ерөнхий хөтөлбөрийн* материалууд тухайн орны хэл дээр байдаггүй газруудад хэрэглэгддэг. *Сургалтын үндсэн хөтөлбөрийн* хуваарь болон материалуудыг харуулсан схем хуудас 4-т байгаа болно.

Сургалтын ерөнхий хөтөлбөр нь *сургалтын үндсэн хөтөлбөр* дээр үндэслэгдэх бөгөөд Сүм сайн төлөвшсөн газруудад хэрэглэгддэг. *Сургалтын ерөнхий хөтөлбөрийн* хуваарь болон материалуудыг харуулсан схем хуудас 5-т байгаа болно.

Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлүүд нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгатай анхлан холбоо барьж зөвшөөрөл авснаар, илүү сайн төлөвшсөн бүсүүдэд болон хэлнүүд дээр *сургалтын үндсэн хөтөлбөр* нь гишүүдэд *сургалтын ерөнхий хөтөлбөрөөс* илүү сайн үйлчилж чадах газруудад *сургалтын үндсэн хөтөлбөрийг* хэрэглэхийг тогтоож болно.

Сургалтын Хөтөлбөрийн Материалуудыг Олж Авах болон Хэрэглэх нь

Жил бүрийн хоёрдугаар хагаст Сүмийн нэгжүүд (1) дараагийн жилийн материалуудын захиалга хийхийн тулд Annual Curriculum Order маягтуудыг (2) хэрэв шаардлагатай бол дараагийн жилүүдийн нэмэлт хувиудыг захиалах маягтуудыг хүлээн авна. Хэсгийн бичиг хэргийн ажилтан буюу түүний туслахуудын нэг нь захиалгын хуудсуудыг бөглөж, хэрэгтэй материалуудыг олж авахад нь санваарын болон хавсралт байгууллагуудын удирдагчдад тусалж болно. Сургалтын хөтөлбөрийн олон материал цуглааны байрны номын санд бас байдаг.

Бүх багш нар батлагдсан сургалтын хөтөлбөрийн материалуудыг ашиглахад нь удирдагчид анхаарах

ёстой. Бас багш нар хичээлүүдийг гарын авлагуудад байгаа дарааллаар нь заахыг урамшуулан дэмжих хэрэгтэй.

Эдгээр заавруудад жагсаагдсан бүх материалууд бүх хэл дээр байдаггүй. Хэрэв та нар аль нэг хэл дээр байгаа материалуудыг олох хэрэгтэй байвал, өөрийнхөө нэгжид үйлчилдэг хангамжийн төвтэй холбоо барь.

Бие Эрхтэний Согогтой Гишүүдэд Зориулсан Сургалтын Хөтөлбөр

Бие эрхтэний согогтой гишүүдийн хэрэгцээнд зориулан хялбаршуулсан Сүмийн сургалтын хөтөлбөрийн материалууд байдгийг удирдагчид тэдэнд мэдүүлэх ёстой. Эдгээр материалуудын талаарх мэдээллийг *Church Materials Catalog*-ыг үзэх буюу өөрийн нэгжид үйлчилдэг хангамжийн төвтэй холбоо барь.

Багшийг Хөгжүүлэх нь

Санваарын болон хавсралт байгууллагын удирдагчид нь өөрсдийн байгууллагууд дахь хичээл заалтын чанарын төлөө хариуцлага хүлээдэг. Багшийн хөгжилд ашиглах материалууд гэвэл: *Improving Gospel Teaching: A Leader's Guide* (35667); *Teaching, No Greater Call* (36123); "Gospel Teaching and Leadership," Сүмийн *Handbook of Instructions, Book 2* (35903) 16 бүлэгт; түүнчлэн *Заах Удирдамж* (34595) болно.

Teaching, No Greater Call болон *Church Handbook of Instructions* номын "Gospel Teaching and Leadership" хэсэг багш бүрд байхад удирдагчид анхаарах хэрэгтэй.

Хэсгийн багшийн хөгжлийн зохицуулагч бол багшийн хөгжлийн өөр нэг чухал эх сурвалж юм. Тэрээр Ням Гарагийн Сургуулийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн удирдлага дор үйлчилдэг хэдий ч, хэсэг дахь бүх байгууллагуудтай хамтран ажилладаг.

ГЭРТ ЗОРИУЛСАН ХӨТӨЛБӨР

Гэр орондоо сайн мэдээг судалж, заах болон үүгээр амьдрахад нь гишүүдэд туслахын тулд Сүм олон материал гаргадаг. Дараах материалууд гэр болгонд байх ёстой (эдгээр нь хэвлэгдэн гарсан хэл дээрээ). Эдгээр материалууд шинэ гишүүдэд байх талаар удирдагчид анхаарал тавихыг хичээх ёстой.

Судрууд

Сүмийн сэтгүүлүүд

Gospel Principles (31110) буюу *Евангелийн*

Үндсүүд (31129)

Hymns (31243)

Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг (35602)
Амьд Христ: Төлөөлөгчдийн Гэрчлэл (36299)
Гэр Бүлийн Удирдамж (31180)
Family Home Evening Resource Book (31106)
Заах Удирдамж (34595)

Түүнчлэн сайн мэдээг гэрт заахад зориулсан нэмэлт материалууд бас байдаг. Эдгээр нь видео бичлэгүүд, сонсох бичлэгүүд, зургууд болон бусад үзүүлэнгүүд, судрууд судлах тусламжууд болон хүүхэд, залуучууд хийгээд насанд хүрэгчдэд зориулсан хэвлэмэл материалууд болно. Дэлгэрэнгүй мэдээллийг *Church Materials Catalog* буюу эсвэл *Family Resource Catalog*-оос үзэж, Интернетэд www.ldscatalog.com хаягаар орох буюу эсвэл өөрийн нэгжид үйлчилдэг хангамжийн төвтэй холбоо барьж болно. Эдгээр материалуудаас олон нь www.lds.org-ын "Home and Family" хэсэгт бий.

СҮМИЙН НЭГЖҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын хөтөлбөрийн жил нь дэлхий даяар Нэгдүгээр сарын 1-нд эхэлдэг. Энэ өдөр хүрсэн насны байдлаар хүүхэд, залуучууд ангиудад зохион байгуулагддаг.

Мелкизедек Санваар ба Нийгмийн Халамжийн Бүлэг

Ихэнх Ням гарагуудад Мелкизедек Санваар атгагчид болон Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар адил сэдвүүдийг судалж, мөн адил материалуудыг ашигладаг. Гэвч тэд тус тусдаа цугладаг.

Нэг дэх Ням Гараг. Мелкизедек Санваарын удирдагчид чуулгын гишүүдэд үүргийг нь зааж, санваарын ажилд идэвхтэй оролцдог болоход нь туслахын тулд энэ цуглааныг ашигладаг. Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид Нийгмийн Халамжийн Бүлгийн зорилго хийгээд үүний ариун ажлын тухай эгч нарт заахад энэ цуглааныг хийнэ.

Эдгээр цуглаануудын сэдвүүд нь гэрлэлтүүд хийгээд гэр бүлүүдийг бэхжүүлэх, гэрийн багшлалт болон айлчлагч багшийн ажил, үйлчлэл, номлогчийн ажил, идэвхжүүлэлт, нөхөрлөл, сүнсний болон цаг зуурын халамж, түүнчлэн ариун сүмийн хийгээд гэр бүлийн түүхийн ажлыг хамарч болно.

Ахлагч нарын чуулга, дээд санваартны бүлэг, түүнчлэн Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид өөр өөрсдийн байгууллагын хувьд энэ цуглааныг тус бүрдээ төлөвлөдөг. Хуудас 4, 5-д жагсаасан сургалтын материалуудыг ашиглан эдгээр удирдагчид уг хичээлүүдийг заадаг. Удирдагчид гишүүдийн хэрэгцээг тогтоож, эдгээр хэрэгцээг нь хэрхэн хамгийн сайнаар хангах вэ гэдгийг анхааран, эдгээр цуглаануудыг залбиралтайгаар бэлтгэх ёстой.

Чуулгын болон бүлгийн Эхний Ням гарагийн цуглаан нь уг чуулга буюу бүлгээс хийх үйлчлэл болон бусад ажлыг төлөвлөх цагийг байнга оруулж байх ёстой. Түүнчлэн эдгээр цуглаанууд нь ёслолуудыг хэрхэн гүйцэтгэхийг харуулах, бусдад хэрхэн туслах, өнгөрсөн хугацаан дахь үүрэг

даалгавруудын биелэлтийг сонсох, үүрэг даалгавар өгөх, түүнчлэн зорилго тодорхойлох цаг гаргадаг байх ёстой.

Нийгмийн Халамжийн Бүлгийн Эхний Ням гарагийн цуглаан нь, илүү итгэлтэй гишүүд хийгээд илүү сайн эхнэрүүд, эхчүүд, охид хийгээд хөршүүд болоход нь эгч нарт туслах ёстой. Хэсгийн халамжийн болон хэсгийн зөвлөлийн цуглаанууд дээр хэлэлцсэн заавруудаас ерөнхийлөгчийн зөвлөл хуваалцах цаг гаргаж болно. Мөн тэд гэрчлэлээ хуваалцах цагийг эгч нарт гарган өгч болно.

Хоёр дахь ба Гурав дахь Ням гарагууд. Сургалтын үндсэн хөтөлбөрийг ашиглаж байгаа нэгжүүдийн хувьд, эдгээр Ням гарагуудын хичээлийг *Санваарын Үүргүүд ба Адислалууд*, *Хожмын Үеийн Гэгээнтэн Эмэгтэй* гарын авлагуудаас авах ёстой. Сургалтын ерөнхий хөтөлбөрийг ашиглаж байгаа нэгжүүдийн хувьд, хичээлийг *Teachings of Presidents of the Church* номноос заана. Хичээлд ашиглагдах энэ номны нэг хувийг гишүүн бүрд өгөх ёстой.

Ахлагч нарын чуулга, дээд санваартнуудын бүлэг, түүнчлэн Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид энэ цуглааныг өөрсдийн байгууллага тус бүрт зориулж тус бүрдээ төлөвлөнө. Эдгээр хичээлүүдийг удирдагчид буюу эсвэл чуулгын болон бүлгийн багш нар эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн багш нар зааж болно.

Хэрэв гадасны чуулганууд буюу бусад цуглаанууд эдгээр хичээлүүдийн аль нэгийг заахыг урьдчилан зөвлөмж болгосон бол, үүнийг өөр Ням гарагт заахыг орон нутгийн удирдагчид шийднэ. Хичээлүүдийг номонд байгаа дарааллаар нь заах ёстой.

Дөрөв дахь Ням Гараг—Манай Үеийн Талаар Заадаг Зүйлүүд. Энэ Ням Гарагийн арван сэдвүүд болон материалуудыг Тэргүүн Зөвлөл жил тутам, ихэвчлэн *Ensign* болон *Лиахона* сэтгүүлүүдийн Тав, Арваннэгдүгээр сарын дугааруудад гаргадаг. Хоёр нэмэлт сэдвийг гадас болон дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөл сонгодог.

Ахлагч нарын чуулга, дээд санваартнуудын бүлэг, түүнчлэн Нийгмийн Халамжийн Бүлгийн удирдагчид энэ цуглааныг өөрсдийн байгууллага тус бүрт зориулж тус бүрдээ төлөвлөнө. Эдгээр хичээлүүдийг удирдагчид буюу эсвэл чуулгын болон бүлгийн багш нар эсвэл Нийгмийн Халамжийн Бүлгийн багш нар зааж болно.

Тав дахь Ням Гараг (байгаа тохиолдолд). Энэ цуглааны сэдвийг бишопын зөвлөл хэсгийнхээ хэрэгцээнд тохируулан тогтооно. Энэ Ням гарагт ахлагч нарын чуулга болон дээд санваартнуудын бүлэг хамтран цуглах буюу эсвэл тэд Нийгмийн Халамжийн Бүлэгтэй нийлж болно.

Аароны Санваар ба Залуу Эмэгтэйчүүд

Аароны Санваарын Чуулгууд ердийн байдлаар Ням гарагийн чуулгын цуглаанууд болон хичээлд тусдаа цугладаг. Гэвч, нэгжид залуу эрэгтэйчүүдийн насны цөөхөн Аароны Санваартнууд байгаа тохиолдолд тэд цуглаанд нийлж болно. Мөн ийм удирдамжийг Залуу Эмэгтэйчүүдийн хичээлүүдэд баримталж болно.

Сургалтын үндсэн хөтөлбөрийг ашиглаж байгаа нэгжүүдэд, хэрэв залуу эрэгтэйчүүдийн тоо цөөхөн байвал, тэд Мелкизедек Санваар атгагчидтай хамт цуглаж болно. Эдгээр нэгжүүд дэх залуу эмэгтэйчүүдийн тоо цөөхөн байвал, тэд Нийгмийн Халамжийн Бүлэгтэй хамт цуглаж болно.

Аароны Санваар атгагчид болон залуу эмэгтэйчүүдэд хуудас 4, 5-д жагсаасан гарын авлагуудаас заана. Удирдагчид зарим хичээлүүдийг заахад тусалцуулахаар залуучуудыг урьж болно. Заах бусад материалууд гэвэл *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (36550), *True to the Faith* (36863) түүнчлэн Сүмийн сэтгүүлүүд байна. *New Era*, *Ensign* сэтгүүлүүдийн Тав, Арваннэгдүгээр сарын дугаарууд, түүнчлэн *Лиакона* нь хичээлүүдийг баяжуулахад ашиглаж болох бусад материалууд хийгээд Сүмийн сэтгүүлийн өгүүлүүдийг ишлэлүүдээр хангадаг эх сурвалжийн удирдамжийг бас агуулсан байдаг.

Хүүхдийн Хэсэг

Удирдагчид Нэгдүгээр сарын 1-нд хүүхдүүдийг насаар нь Хүүхдийн Хэсэгт бүлгүүд болгох ёстой. Хэрэв хүүхдүүдийн тоо хангалттай байвал, насны бүлэг бүрд тусгай анги зохион байгуулагдах ёстой. Анги танхимын болон багш нарын тоо хязгаардагдмал байвал, янз бүрийн насны хүүхдүүдийг хамтад нь нэг бүлэг болгож болно.

Сургалтын ерөнхий хөтөлбөр ашиглаж байгаа нэгжүүдэд боломжтой бол, хүүхдүүд 18 сар хүрсэн үед тэдэнд зориулсан хүүхэд саатуулах анги байж болно. Энэ ангид хүүхдүүдээ оруулах нь эцэг эхийн сонголт байдаг. Нэгдүгээр сарын 1 гэхэд 2 нас хүрсэн хүүхдүүд жилийн эцэс хүртэл хүүхэд саатуулах ангидаа үргэлжлэн явна. Нэгдүгээр сарын 1 гэхэд 3 нас хүрсэн хүүхдүүд Санбим 4 анги буюу бага насны нэгдсэн ангид явна.

Хуудас 4, 5 дахь бүдүүвчид харуулсан гарын авлагуудаас хүүхдүүдэд заана. Заах бусад эх сурвалжууд гэвэл Сүмийн сэтгүүлүүд, зураг чимэглэл бүхий судрын унших хэсгүүд, Сайн Мэдээний Уран Зургийн Цуглуулга, тэрчлэн *Хүүхдийн Дууны Ном* болно.

Боломжтой газруудад, бага насны хүүхдүүд Хүүхдийн Хэсгийн хуваалцах цагт оролцдог бол ахлах насны хүүхдүүд хичээлд оролцдог. Хүүхдийн Хэсгээр дамжин, явцын дунд хоёр бүлэг байраа солино. Хүүхдийн тоо цөөхөн байгаа үед хоёр бүлэг нийлж болно. Хэрэв хоёр бүлэг тусдаа цугладаг бол, ахлах насны хүүхдүүдийн хуваалцах цаг нь Аароны Санваарын болон Залуу Эмэгтэйчүүдийн хуваалцах цагийн үеэр явагдах ёстой.

Тухайн жилд 12 нас хүрэх хүүхдүүд дараа оны Нэгдүгээр сар хүртэл Хүүхдийн Хэсгийн хичээлдээ үргэлжлүүлэн явна. Гэвч Хүүхдийн Хэсгийн хуваалцах цагийн үеэр тэд Аароны Санваарын чуулгын цуглаан буюу эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн хичээлд оролцож эхэлдэг.

Ням Гарагийн Сургууль

Ням Гарагийн Сургууль бол насанд хүрэгчдэд болон Нэгдүгээр сарын 1 гэхэд 12 настай болсон мөн түүнээс дээш насны залуучуудад зориулагддаг. Тухайн жилд 12 хүрч байгаа хүүхдүүд Ням Гарагийн Сургуулийн үеэр Хүүхдийн Хэсэгтээ үлдэнэ.

Залуучуудын тоо хангалттай байгаа үед насны бүлэг бүрд ангиудыг тусад нь зохион байгуулж болно. Залуучуудын тоо цөөхөн буюу эсвэл анги танхим, багш нар хязгаарлагдмал байгаа үед янз бүрийн насны залуусыг нэг бүлэгт хуваарилан зохион байгуулж болно.

Ням Гарагийн Сургуулийн хичээлүүд болон тэдгээрийг заах материалуудыг хуудас 4, 5 дахь бүдүүвчид харуулсан болно.

Сонгон Заах Хичээлүүд

Сонгон заах хичээлүүдийн талаарх мэдээллийг хуудас 4, 5 дахь бүдүүвчээс үз. Эдгээр хичээлүүдийг бишопын зөвлөл шаардлагатай гэж үзсэний дагуу заана. Эдгээр хичээлүүдийг оролцогчдын тохиромжтой цагт, түүний дотор Ням Гарагийн Сургуулийн үеэр явуулна.

Сүмийн Нэгжүүдэд Зориулсан Сургалтын Үндсэн Хөтөлбөр¹

(Сүм саяхан зохион байгуулагдсан буюу сургалтын ерөнхий хөтөлбөрийн материалууд байхгүй газарт ашиглана)

Зохион байгуулалт	Гарын Авлагууд ба Ашиглах Материалууд	2005	2006	2007	2008
Мелкизедек Санваар ба Нийгмийн Халамжийн Бүлэг	Нэг дэх Ням Гаргууд Удирдагчид өөрийн орны хэл дээр хэвлэгдсэн дараах материалуудыг ашиглаж болно: судрууд; Сүмийн сэтгүүлүүд; Санваарын болон Хавсралт Байгууллагуудын Удирдамж (31178); Гэр Бүлийн Удирдамж (31180); Заах Удирдамж (34595); Санваарын Үүргүүд болон Адислалууд, Хэсэг А (31111), Хэсэг Б (31112); Хожмын үеийн Гэгээнтэн Эмэгтэй, Хэсэг А (31113), Хэсэг Б (31114); түүнчлэн Gospel Principles (31110) болон Евангелийн Үндсүүд (31129)	•	•	•	•
	Хоёр дахь ба Гурав дахь Ням Гаргууд Санваарын Үүргүүд болон Адислалууд, Хэсэг А (31111) буюу Хожмын үеийн Гэгээнтэн Эмэгтэй, Хэсэг А (31113)	•	•		
	Санваарын Үүргүүд болон Адислалууд, Хэсэг Б (31112); буюу Хожмын үеийн Гэгээнтэн Эмэгтэй, Хэсэг Б (31114)			•	•
	Дөрөв дэх Ням Гаргууд Манай Үеийн Талаар Заадаг Зүйлүүд талаарх материалуудыг Тэргүүн Зөвлөл гаргадаг (Хэрэв эдгээр материалууд тухайн орны хэл дээр байхгүй бол, Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичгүүд болон Айлчлагч Багшийн Захиас Бичгүүдийг ашиглаж болно. Эдгээр нь Сүмийн сэтгүүлүүдэд нийтлэгддэг буюу эсвэл сэтгүүлүүд очдоггүй бүсүүдэд тусад нь хүргүүлдэг).	•	•	•	•
	Тавь дахь Ням Гаргууд: Сэдвүүд болон ашиглах материалуудыг салбарын ерөнхийлөгчийн зөвлөл тогтооно.	•	•	•	•
Аароны Санваар ба Залуу Эмэгтэйчүүд	1 дэх, 4 дэх ба 5 дахь Ням Гаргууд Аароны Санваар 1 (34820) буюу Залуу Эмэгтэйчүүд 1 (34823). Хичээлүүдийг дарааллаар нь хоёр жил заагаад, дараа нь давтана.2	•	•	•	•
	2 дахь ба 3 дахь Ням Гаргууд Санваарын Үүргүүд болон Адислалууд, Хэсэг А (31111) буюу Хожмын үеийн Гэгээнтэн Эмэгтэй, Хэсэг А (31113)	•	•		
	Санваарын Үүргүүд болон Адислалууд, Хэсэг Б (31112) буюу Хожмын үеийн Гэгээнтэн Эмэгтэй, Хэсэг Б (31114)			•	•
Хүүхдийн Хэсэг	Нас 3 Хүүхдийн Хэсэг 1: I Am a Child of God (34969)	•	•	•	•
	Нас 4–7 Хүүхдийн Хэсэг 2: Зөвийг Сонго А (34484)		•		•
	Хүүхдийн Хэсэг 3: Зөвийг Сонго Б (34499)	•		•	
	Нас 8–11 Шинэ Гэрээ (34604)	•		•	
	Мормоны Ном (34594)		•		•
Ням Гарагийн Сургууль	Нас 12—насанд хүрсэн Gospel Principles (31110) буюу Евангелийн Үндсүүд (31129). Энэ хичээл бол сонирхогчид болон сайн мэдээний үндсэн зааврыг хүсдэг бусад хүмүүст зориулагдсан юм.	•	•	•	•
	Мормоны Номон дахь Сайн Мэдээний Сургаал Заах Багшийн Гарын Авлага (35683)				•
	Сургаал ба Гэрээ болон Church History Gospel Doctrine Teacher's Manual (35685) болон Our Heritage (35448)	•			
	Old Testament Gospel Doctrine Teacher's Manual (35570)		•		
	Шинэ Гэрээн дэх Сайн Мэдээний Сургаал Заах Багшийн Гарын Авлага (35681)			•	
Сонголтоор Заах Хичээлүүд					
Сайн Мэдээний Курсыг Заах нь	Заах Удирдамж (34595) (8 долоо хоног; энэ курсыг төлөвлөхийн тулд Заах Удирдамжийн хуудас 22–23–ыг үз)	•	•	•	•
Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцааны Курс Хичээл	Marriage and Family Relations Instructor's Manual (35865) Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцаа: Оролцогчийн Судлах Гарын Авлага (36357) (16 долоо хоног; салбарын ерөнхийлөгчийн дуудсан багш заана)	•	•	•	•

1. Энэ бүдүүвчин дэх бүх материалууд бүх хэл дээр орчуулагдаагүй болно, иймээс сургалтын үндсэн хөтөлбөрийг ашигла. Эдгээр материалуудаас олдсоноор нь ашигла. Ямар материалууд байгаа талаар хангамжийн төвтэй холбоо барьж асуу.
2. Хэрэв Аароны Санваар 1 болон Залуу Эмэгтэйчүүд 1 удирдамжууд байхгүй бол, Санваарын Үүргүүд болон Адислалууд, Хожмын Үеийн Гэгээнтэн Эмэгтэй гарын авлагуудыг нэг дэх, дөрөв дэх болон тав дахь Ням гарагуудын хичээлд ашигла.

Сүмийн Нэгжүүдэд Зориулсан Сургалтын Ерөнхий Хөтөлбөр
(Сүм сайн төлөвшсөн газруудад ашиглагдана)

Зохион байгуулалт	Гарын Авлагууд болон Эх Сурвалж Материалууд	2005	2006	2007	2008
Мелкизедек Санваар ба Нийгмийн Халамжийн Бүлэг	Нэг дэх Ням Гарууд Удирдагчид дараах материалуудыг ашиглаж болно: судрууд; Сүмийн сэтгүүлүүд; <i>Church Handbook of Instructions, Ном 2</i> (35209), хэсэг 1, 3, 7, 8, 9, 16; <i>Санваарын Үүргүүд болон Адислалууд, Хэсэг А</i> (31111), <i>Хэсэг Б</i> (31112); <i>Хожмын үеийн Гэгээнтэн Эмэгтэй, Хэсэг А</i> (31113), <i>Хэсэг Б</i> (31114); <i>Gospel Principles</i> (31110); <i>Worldwide Leadership Training Meeting</i> товхимолууд түүнчлэн <i>A Member's Guide to Temple and Family History Work</i> (34697).	•	•	•	•
	Хоёр дахь ба Гурав дахь Ням Гарууд: Одоогийн <i>Teachings of Presidents of the Church</i> ном	•	•	•	•
	Дөрөв дэх Ням Гарууд: Тэргүүн Зөвлөлөөс Гаргадаг Манай Үеийн Талаар Заадаг Зүйлүүд ын материалууд	•	•	•	•
	5 дахь Ням Гарууд: Сэдвүүд болон ашиглах материалуудыг бишопын зөвлөл тогтооно	•	•	•	•
Аароны Санваар ба Залуу Эмэгтэйчүүд	<i>Аароны Санваар 1</i> (34820) буюу <i>Залуу Эмэгтэйчүүд 1</i> (34823)		•		
	<i>Аароны Санваар 2</i> (34821) буюу <i>Залуу Эмэгтэйчүүд 2</i> (34824)			•	
	<i>Aaronic Priesthood 3</i> (34822) буюу <i>Young Women 3</i> (34825)	•			•
Хүүхдийн Хэсэг	Нас 18 сараас—3 жил (Хүүхэд Саатуулах болон Санбим 4 ангиуд) <i>Хүүхдийн Хэсэг 1: I Am Child of God</i> (34969)	•	•	•	•
	Нас 4–7 (ЗС 5, 6, 7 ба 8 ангиуд) <i>Хүүхдийн Хэсэг 2: Зөвийг Сонго А</i> (34484)		•		•
	<i>Хүүхдийн Хэсэг 3: Зөвийг Сонго Б</i> (34499)	•		•	
	Нас 8–11(Валиэнт 9, 10, 11 ба 12 ангиуд) <i>Хүүхдийн Хэсэг 4: Мормоны Ном</i> (34594)				•
	<i>Хүүхдийн Хэсэг 5: Doctrine and Covenants and Church History</i> (34602)	•			
	<i>Хүүхдийн Хэсэг 6: Old Testament</i> (34603)		•		
	<i>Хүүхдийн Хэсэг 7: Шинэ Гэрээ</i> (34604)			•	
Ням Гарагийн Сургууль	Нас 12–13 <i>Preparing for Exaltation Teacher's Manual</i> (31384)		•		•
	<i>The Presidents of the Church Teacher's Manual</i> (31382)	•		•	
	Нас 14–насанд хүрсэн <i>Мормоны Номон дахь Сайн Мэдээний Сургаал Заах Багшийн Гарын Авлага</i> (35683)				•
	<i>Doctrine and Covenants and Church History Gospel Doctrine Teacher's Manual</i> (35685) болон <i>Our Heritage</i> (35448)	•			
	<i>Old Testament Gospel Doctrine Teacher's Manual</i> (35570)		•		
	<i>Шинэ Гэрээн дэх Сайн Мэдээний Сургаал Заах Багшийн Гарын Авлага</i> (35681)			•	
	Нас 14–насанд хүрсэн <i>Gospel Principles</i> (31110). Энэ курс хичээл бол сонирхогчид болон сайн мэдээний үндсэн зааврыг хүсдэг бусад хүмүүст зориулагдсан болно.	•	•	•	•
Сонголтоор Заах Хичээлүүд					
Сайн Мэдээний Курсийг Заах нь	<i>Teaching, No Greater Call</i> (36123) (12 долоо хоног; ихэвчлэн хэсгийн багшийн хөгжлийн зохицуулагч заана)	•	•	•	•
Гэрлэлт ба Гэр бүлийн Харилцааны Курс Хичээл	<i>Marriage and Family Relations Instructor's Manual</i> (35865) <i>Гэр Бүл ба Гэр Бүлийн Харилцаа: Орологчийн Судлах Гарын Авлага</i> (36357) (16 долоо хоног; бишопын зөвлөлийн дуудсан багш заана)	•	•	•	•
Гэр Бүлийн Түүхийн Курс Хичээл	<i>A Member's Guide to Temple and Family History Work</i> (34697) (долоо хоногуудаар өөрчлөгдөнө; ихэвчлэн хэсгийн гэр бүлийн түүхийн зөвлөх заана)	•	•	•	•

Ариун Сүмийн Бэлтгэлийн Курс Хичээл	Дээрээс Хишиг Хүртээгдэгсэд: Ариун Сүмийн Бэлтгэлийн Семинарын Багшийн Гарын Авлага (36854) Ариун Сүмд Орохоор Бэлтгэх нь (36793) (7 долоо хоног)	•	•	•	•
---	---	---	---	---	---

© 2004 by Intellectual Reserve, Inc. Бүх эрхийг эдэлнэ. АНУ-д хэвлэв. Англи эхийн зөвшөөрөл: 8/03. Орчуулгын зөвшөөрөл: 08/03. *Information for Priesthood and Auxiliary Leaders on Curriculum 2005 through 2008*-ын орчуулга. Mongolian 36904 363